



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 31-ны өдөр

Дугаар А/73

Эрхэмт

Аян зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 заалт, Эрүүл ахуйн тухай хуулийн 11дүгээр зүйлийн 11.1.1, Хөг хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл ахуйн гурван дадал аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай 185540 /нэг зуун наян таван мянга таван зуун дөч төгрөг /-ийг төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Аяныг хариуцлагатай зохион байгуулж үр дүнтэй ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж мэргэжил аргагүйгээр хангаж ажиллахыг НЭМТ / А.Баярхүү/-д даалгасугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
11/07 дугаар сарын 21-ны өдрийн
11/28 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|----------------------|----------------------------------------------------------------------------------------------|
| Ажлын хэсгийн дарга: | - Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга |
| Гишүүд: | - Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл сургалт
сурталчилгаа хариуцсан ажилтан |
| | - Зураглаач |
| Нарийн бичиг: | - Эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй
байдалын асуудал хариусан мэргэжилтэн |

**"ЭРҮҮЛ АХУЙН ГУРВАН ДАДАЛ АЯН"-ЫГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

Үндэслэл:

Сүүлийн жилүүдэд хүн амын механик шилжилт хөдөлгөөнтэй холбоотой Орхон аймгийн хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж, гэр хороолол хүрээгээ тэлж, автомашин техникийн тоо хурдацтай өсч, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ өргөжиж байгаа нь хүрээлэн буй орчны бохирдолд шууд ба дам байдлаар хүчтэй нөлөөлж байна.

Орхон аймаг нь гэр хорооллын 16.000 мянган айл өрхтэй ба нүхэн жорлон - 12406, бохирын цоног-3506 байна. Айл өрхийн 56,5% нь хашаан дахь нүхэн жорлонгоо 3 буюу түүнээс дээш удаа сэлгэсэн, дахин барих газаргүй, 60,7% нь агааржуулалтгүй, 45,7% нь хлорын шохойгоор халдваргүйжүүлдэг талаар статистик судалгаа байна.

Хөрс, агаар, орчны бохирдол нь хүний эрүүл мэндэд өндөр эрсдэлтэйг эрдэмтэд судалж мэдээлсээр байгаа боловч хогоо гудамжинд хаях, бохир усаа ил задгай асгах, нус цэр шүлсээ гудамж талбайд хаядаг буруу зуршил иргэдийн дунд оршоор байна.

Зорилго: Эрүүл, аюулгүй, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх арга хэмжээг аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран өргөн цар хүрээтэй зохион байгуулах

Зорилт:

1. Эрүүл ахуйн 3 дадалыг хэвшүүлэх уриалгыг аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлж хамтран ажиллах
2. Хог хаягдлыг зөв ангилж устгах дадал зуршлыг хэвшүүлэх, сурталчлах
3. Нүхэн жорлонг тогтмол халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж мэдээлэл сургалт сурталчилгааг өргөжүүлэх
4. Гарын эрүүл ахуй, гар угаахын ач холбогдлыг сурталчлах

Хэрэгжүүлэгч байгууллага: Орхон аймгийн Эрүүл мэндийн газар – Нийгмийн эрүүл мэндийн төв

Хамрах хүрээ: Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус нэгж байгууллага, айл өрх иргэд хамрагдана

Хугацаа: 2020 оны 08 дугаар сарын 03-аас 10 дугаар сарын 01 –ийг хүртэл

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжилтийг шууд хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Нэг. Ерөнхий удирдлага, зохион байгууллалт				
1	"Эрүүл орчин –Элэг бүтэн байх үндэс" туг аялуулах	III-р улиралд	ЭМГ	Бүх аж ахуй нэгж байгууллагууд
3	Эрүүл ахуйн дадлыг хэвшүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааг хүргэх үйл ажиллагааг цахим орчинд өргөн цар хүрээтэй зохион байгуулах	II, III-р улиралд	ЭМГ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд
4	Нийтийн эзэмшлийн газарт нус, цэр, тамхины ишээ ил задгай хаяхгүй байхыг хөдөлгөөн өрнүүлж мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	III-р улиралд	ЭМГ	ӨЭМТ-үүд, Улаан загалмайн нийгэмлэг
5	Эрүүл ахуйн аяны суурь болон төгсгөлийн үнэлгээ хийж үр дүнг тайлагнах	II, III-р улиралд	ЭМГ	СӨЭМТ-үүд
Хоёр. Гар угаах нөхцөлийг сайжруулж гараа тогтмол зөв угаах дадалыг хэвшүүлэх үйл ажиллагаа				
2.1 ЕБС, цэцэрлэгийн гар угаах дадал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үйл ажиллагаа				
6	Сургууль цэцэрлэгийн гар угаах орчинд үнэлгээ хийж стандарт орчин бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах	III-р улиралд	ЭМГ	БСУГ
7	Гарын эрүүл ахуйн стандарт орчин бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийг сурталчилах, уриалах	III-р улиралд	ЭМГ	БСУГ
Гурав. Суурьшлын хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагаа				
3.1 Гэр хорооллын суурьшлын орчны хог хаягдлын менежментийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа				
8	Хог хаягдлыг зөв ангилж устгах дадал зуршлыг хэвшүүлэх , сурталчилах	III-р улиралд	ЭМГ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд
9	Хог хаягдлын ангилал устгалд тандалт судалгаа хийх , салбар дундын хамтарсан уулзалт зохион байгуулах	III-р улиралд	ЭМГ	Баян-Өндөр сум, ӨЭМТ-үүд, Хот тохижуулах газар
10	Хог хаягдлыг ангилах устгалын хамгийн зөв шийдэлтэй байгууллага аж ахуй нэгж өрхийн тэргүүн туршлагыг сурталчилах	III-р улиралд	ЭМГ	БаянӨндөр сум Хэвлэл мэдээллийн байгууллагууд
Нүхэн жорлонгоо сайжруулах, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагаа				

11	Эко ариун цэврийн байгууламж төслийн ажлыг сурталчилж, мэдээллээр хангах	III-р улиралд	ЭМГ	БаянӨндөр сум Хэвлэл мэдээллийн байгууллагууд
12	Нүхэн жорлонг тогтмол халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах мэдээлэл сургалт сурталчилгааг өргөжүүлэх	III-р улиралд	ЭМГ	Баян-Өндөр сум, ӨЗМТ-үүд
13	Эко болон стандарт, аюулгүй ариун цэврийн байгууламжтай айл өрхийг сурталчилж тэргүүн туршлагыг сурталчилах	III-р улиралд	ЭМГ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН ХТХАБАХМ *Найман* Т.Байгаль

ХЯНАСАН НЭМТ

Сүмбэр А.БАЯРХҮҮ